# ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ДҮҮРИЙМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | |
| **1** | Арга хэмжээ №1.1. ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн шаардлагатай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцон | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | ГЕГ-ын даргын тушаалаар 2019-2022 оны хооронд батлагдсан захиргааны хэм хэмжээний актад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн шаардлагатай журам зааврыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах арга хэмжээнд зохион байгуулахад оролцоно. | Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын хуралдааны 2022 оны 55 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолыг удирдлага болгон Гаалийн ерөнхий газрын даргын хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд баталсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хийж гүйцэтгэн 17 хуудас бүхий хавсралтыг ГЕГ-ын даргын 2024.09.26-ны өдрийн №01/3943 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Үүнд:<br>1.Захиргааны хэм хэмжээний актын үндэслэл болгосон хууль, хуулийн заалт хүчинтэй эсэх;<br>2.Хавсралтаар баталсан журам, зааврыг батлан гаргах эрх хуулиар олгогдсон эсэх;<br>3.Бусад захиргааны хэм хэмжээний акттай давхардсан, зөрчилдсөн, хууль тогтоомжид нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, зүйл, заалт байгаа эсэх;<br>4.Батлагдсан захиргааны хэм хэмжээний акт доторх зүйл, заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа эсэх, зөрчилдөж байвал хэрхэн залруулах;<br>5.Захиргааны хэм хэмжээний зүйл, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулах шаардлага, үндэслэл байгаа эсэх;<br>6.Тухайн захиргааны хэм хэмжээний акт Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй эсэх;<br>7.Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх; | 01.01-12.10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 8.Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн түвшин /бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зэрэг болно. (дэлгэрэнгүйг хавсралтаар оруулав)<br>Дүгнэлтийн дагуу 2024 онд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:<br>1.ГЕГ-ын даргын 2016 оны “Харьяа байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай” А/83 дугаар тушаалын үндэслэл болгосон Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчингүй болсон. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023.01.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2023 оны “Согтууруулах ундааг импортлох, экспортлох хилийн боомтыг тогтоох тухай” 146 дугаар тогтоол батлагдсан.<br>Иймд тус хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор ГЕГ-ын даргын 2016 оны “Харьяа байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай” А/83 дугаар тушаалыг хүчингүй болгож, ГЕГ-ын даргын 2023.05.08-ны өдрийн А/301 дүгээр тушаал шинэчлэгдсэн батлагдсан.<br>2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн үйлчлэлийн хугацаа 2022.12.31-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан ГЕГ-ын даргын 2022.12.30-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/350 дугаар тушаалаар “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж, “Зорчигчийн гаалийн мэдүүлэг”-ийн маягтыг хавсралтаар шинэчлэн баталж, ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Зорчигчийн гаалийн мэдүүлэг”-ийн маягтыг хүчингүй болгосон.<br>2.ГЕГ-ын даргын дангаар болон хамтарсан тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах эрх хуулиар бүрэн олгогдсон байна.<br>3.Захиргааны хэм хэмжээний 35 актыг бусад хууль тогтоомжтой нийцэж байна гэж дүгнэсэн бол 1 эрхийн актын зарим зүйл, заалт бусад хууль тогтоомжтой нийцэхгүй байна.<br>4.Батлагдсан захиргааны хэм хэмжээний акт доторх зүйл, заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт байхгүй.<br>5.ГЕГ-ын даргын 2023 оны А/315-р тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д Авлигатай тэмцэх газрын 2024.03.19-ний өдрийн 01/4936 дугаартай албан бичгээр дээрх журмын зарим зүйл заалт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэхээр байна гэсэн зөвлөмж ирүүлсний дагуу тус | |

журмыг дахин шинэчлэн боловруулж ГЕГ-ын даргын 2024 оны “Журам батлах тухай” А/422-р тушаалаар хүчингүй;

**6.**ГЕГ-ын даргын дангаар болон хамтарсан тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх 36 захиргааны хэм хэмжээний акт Улсын нэгдсэн санд бүртгэгдсэн. Түүнээс **ГЕГ-ын даргын тушаалаар 6 захиргааны хэм хэмжээний** актыг хүчингүй болгон, шинээр баталж шийдвэрийг Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Үүнд:

| № | Шийдвэрийн огноо | шийдвэрийн дугаар | Шийдвэрийн гарчиг | Гаальтай холбогдох зүйл, хэсэг, эсхүл товч утга, онцлог | Энэ тушаалаар хүчингүй болсон, нэмэлт өөрчлөлт орсон тушаал, тушаалын заалт | ХЗДХЯ-д бүртгэгдсэн дугаар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2022.12.12 | А/338 | Шалгуур батлах тухай | “Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур” | 2019 оны А/128-р тушаалыг хүчингүй болгосон. | 6069-т бүртгэсэн |
| 2 | 2022.12.12 | А/339 | Журам батлах тухай | “Гаалийн хяналтын бүсийн журам”-д | 2019 оны А/294-р тушаалыг хүчингүй болгосон | 6070-д бүртгэсэн |
| 3 | 2022.12.14 | А/341 | Журам батлах тухай | “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих” журам | 2010 оны 388, 2014 оны А/53-р тушаалыг хүчингүй болгосон | 6082-д бүртгэсэн |
| 4 | 2023.05.08 | А/301 | Тушаал хүчингүй болгох тухай | 2016 оны "Харьяа гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай" А/83-р тушаалыг | 2016 оны А/83 дугаар тушаалыг хүчингүй болгосон | 4526-д бүртгэсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүчингүй болгосон | | |
| 5 | 2024.07.19 | А/422 | Журам шинэчлэн батлах тухай | "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам" | 2019 оны А/226, 2023 оны А/315 дугаар тушаалыг хүчингүй болгосон | 6919-д бүртгэсэн |
| 6 | 2024.07.01 | А/395 | Журам батлах тухай | Бүрдүүлэлтийн дараах шалгалтын журам | 2022 оны А/344-р тушаалыг хүчингүй болгосон | 6900-д бүртгэсэн. |

**ГЕГ-ын даргын баталсан 3 захиргааны хэм хэмжээний актад оруулсан 4 нэмэлт, өөрчлөлтийн шийдвэрийг мөн нэгдсэн санд бүртгүүлсэн. Үүнд:**

| № | Шийдвэрийн огноо | шийдвэрийн дугаар | Шийдвэрийн гарчиг | Гаальтай холбогдох зүйл, хэсэг, эсхүл товч утга, онцлог | Энэ тушаалаар хүчингүй болсон, нэмэлт өөрчлөлт орсон тушаал, тушаалын заалт | ХЗДХЯ-д бүртгэгдсэн дугаар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2022.12.30 | А/350 | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт 2.2.15 дахь заалтыг нэмсүгэй. | 2019 оны А/223 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулсан. А/223 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг хүчингүй болгосон | 4511-т хөлдөлгөөн хийсэн |
| 2 | 2022.12.30 | А/351 | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Чөлөөт | 2019 оны А/282 дугаар тушаалаар батлагдс | 4571-д хөдөлгөөн хийсэн |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>бүсийн горим хэрэгжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.20 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</td><td>ан журамд нэмэлт өөрчлөлт оруулсан</td><td></td></tr>
<tr><td>3</td><td>2023.06.05</td><td>А/366</td><td>Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</td><td>Журам батлах тухай" 680 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Бараа устгах горим хэрэгжүүлэх журам"-ын 2.2 дахь заалтын хүснэгтийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.</td><td>2008 оны 680 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулсан.</td><td>2985-д хөдөлгөөн хийсэн.</td></tr>
<tr><td>4</td><td>2024.06.06</td><td>А/338</td><td>Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</td><td>"Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.6</td><td>2019 оны А/282 дугаар тушаалд</td><td>4571-д хөдөлгөөн хийсэн</td></tr>
</table>
7.Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний акт байхгүй;
</td><td></td></tr>
<tr><td></td><td>Арга хэмжээ №1.2. Харьяа гаалийн газар, хорооны дарга нарын бүрэн эрхийн хүрээнд батлан гаргадаг тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил</td><td></td><td></td><td>Харьяа гаалийн газар, хорооны дарга нарын бүрэн эрхийн хүрээнд батлан гаргадаг тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн</td><td>2024 оны эхний 11 сарын байдлаар ГЕГ-ын харьяа гаалийн газар, хорооны дарга нарын 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 01-10 дугаар сард баталсан нийт 1483 тушаалыг хянасан. Тайлант хугацаанд нийт баталсан тушаалын 93.99 хувийг ГЕГ-ын даргын 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дахь заалтыг үндэслэн хугацаанд нь ирүүлсэн байна. 2024 онд ГЕГ-ын харьяа 19 гаалийн газар, хорооны дарга нарын 1483 тушаалыг хянаж 217 алдаа, зөрчил (үүнээс 89 тушаал хугацаа хоцроосон) илрүүлж “Захиргааны акт хянаж, зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай” зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.</td><td>01.01-12.10</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | арга зүйн удирдлагаар хангасан байна | | | удирдлагаар хангасан байна. | Тайлант хугацаанд нийт харьяа 18 гаалийн газар, хороодод 59 зөвлөмж хүргүүлсний дагуу 18 газар, хороо зөвлөмжийн дагуу тушаалд засвар хийж, дахин хянуулахаар 124 тушаалыг ирүүлсэн байна.<br>2024 онд хянуулахаар ирүүлсэн нийт тушаалын 14.63 хувь нь алдаа, зөрчилтэй байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад алдаатай тушаалын **тоо 3.37** хувиар буурсан байна. Энэ нь нийтлэг батлан гаргадаг түгээмэл тушаалын үлгэрчилсэн загварыг боловсруулж харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэнтэй холбоотой гэж дүгнэж байна. Мөн нийт тушаалын 6.02 хувийг хугацаа хоцроож ирүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.08 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>Тайлант хугацаанд харьяа гаалийн газар, хорооны даргын бүрэн эрхийг хэтрүүлж баталсан 5 тушаалыг хүчингүй болгуулах арга хэмжээ авч ажилласан.<br>Мөн 14 хоног тутмын шуурхай хуралдаанаар харьяа гаалийн газар, хороодын дарга нарт Хуулийн хэлтсээс тухай бүр зөвлөмж, зөвлөгөө өгөн ажилласан.<br>Мөн ГЕГ-ын Гаалийн газар, хороодын дарга нар Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/123 дугаар тушаалын хавсралтаар тухайн Гаалийн газар, хорооны зохион байгуулалтын бүтэц орон тоонд батлагдсан байнгын болон улирлын шинжтэй төрийн үйлчилгээний албан хаагчийг ажилд томилох тушаал батлан гаргахдаа төрийн үйлчилгээний албан хаагчийн хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлүүдийг олгох ёстой.<br>Харин тухайн Гаалийн газар, хорооноос гэрээгээр ажиллуулахаар гэрээт ажилтныг ажилд томилох тушаал батлан гаргахдаа цалин хөлсийг Хөдөлмөрийн гэрээгээр зохицуулах учраас төрийн үйлчилгээний албан хаагчийн бусад нэмэгдлүүдийг олгохгүй байх.<br>Иймд Гаалийн ерөнхий газрын харьяа Гаалийн газар, хороодын дарга, албан хаагч нар дээрх зөвлөмж, чиглэлийн мөрдөж ажиллах талаар харьяа гаалийн 19 газар, хороодын дарга нарт ГЕГ-ын №01-1.2/4949 албан бичгээр зөвлөмж чиглэл хүргүүлэв. | |
| 2 | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ГЕГ-аас батлан гаргах захиргааны хэм хэмжээний акт, захиргааны актын төслийн хууль зүйн үндэслэл нь | **НЭГ:** Тайлант хугацаанд ГЕГ-аас батлан гаргах дараах захиргааны хэм хэмжээний актын төслийг хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавьж, санал өгч ажилласан. Үүнд:<br>**1**. "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам"-ын төсөл,<br>**2**. ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл, | 01.01-12.10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгсөн байх | **3**. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн төсөлд дараах саналыг 2024.05.27-ны өдрийн 01/2055 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.(хавсралт 2 хуудас)<br>**4**."Улсын хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд халдваргүйжүүлэлт хийх журам"-ын төслийг хүлээн авч танилцаад 2024.05.29-ний өдрийн №230 дотоод зурвасаар дараах хариуг хаүргүүлсэн.<br>**5**. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2024.05.24-ны өдрийн №01/1817, Сангийн яамны 2024.06.19-ны өдрийн №03/5249 албан тоотоор "Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журам"-ын төсөлд санал авахаар ирүүлсэн.<br>Холбогдох нэгжүүдээс саналыг авч нэгтгэн 2024.07.08-ны өдрийн №01/2770 албан бичгээр тус яаманд хүргүүлсэн.<br>**6**.Монгол улсын сангийн яамны 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн "Мэдээлэл авах тухай" №03/8072 дугаар албан бичгээр УИХ гишүүн Х.Ганхуягаас 2024.09.19-ны өдрийн УИХ-03/3238 тоот "Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон тусгай, энгийн зөвшөөрлийн статистик тоон мэдээлэл, тус хуулиар эрх олгогдсон тусгай энгийн зөвшөөрлийн мэдээлэл, бүртгэлээр баталгаажуулан эрх олгож буй үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл ирүүл гэсний дагууу Гаалийн байгууллагаас олгодог тусгай 6, энгийн 1 тусгай зөвшөөрлийн мэдээллийг ГЕГ-ын 2024.10.02-ны өдрийн №4023 албан бичгээр 2 хуудас хавсралтыг хүргүүлсэн.<br>**ХОЁР:** Тайлант хугацаанд Гаалийн байгууллагаас төрийн болон бус байгууллагатай байгуулж буй нийт 10 гэрээний төслийг хянаж төслийн хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, дотоод зурвасаар санал өгсөн байна.<br>1. **Ажил гүйцэтгэх гэрээ-5**<br>**2. Худалдах худалдан авах гэрээ-3**<br>**3. Хамтран ажиллах гэрээ-2**<br>3. "Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп" хаалттай бүлэг ажиллуулах дүрмийн төслийг хянаад 2024.05.20-ны өдрийн 217 дугаар дотоод зурвасаар хариуг хүргүүлсэн. | |
| 3 | Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газрын даргын олгосон итгэмжлэлийн | **НЭГ**.Гаалийн ерөнхий газарт холбогдуулан гаргасан захиргааны 2 хэрэгт ГЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримт, тайлбар гаргах, шүүх хуралдаанд мэтгэлцэн оролцох, гомдол гаргах зэргээр ажилласан. Үүнд:<br>**1.** Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй Л.Байгалмаагийн нэхэмжлэлтэй Гаалийн ерөнхий газарт холбогдох "төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоос татгалзаж шийдвэрлэсэн Гаалийн ерөнхий газрын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01-1.1/3968 дугаартай | 01.01-12.10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | үндсэн дээр нэхэмжлэгч, хариуцагч, иргэний хохирогчоор оролцсон талаар, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хамтран ажилласан байна. | албан бичгийг хууль бус болохыг тогтоолгох, Л.Байгалмаад нэг удаагийн буцалтгүй тусламжийг холбогдох журмын дагуу тооцож олгохыг Гаалийн ерөнхий газарт даалгах" шаардлага бүхий захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож холбогдох хариу тайлбар, нотлох баримтыг гарган өгч шүүх хуралдаанд оролцсон.<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2024/0171 дүгээр шийдвэрээр Л.Байгалмаагийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.<br>**2.** О.Отгонбаярын нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газрын даргад холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож холбогдох нотлох баримт, хариу тайлбарыг гаргаж өгсөн. Уг хэргийн урдчилсан хэлэлцүүлэг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр болсон. Урдчилсан хэлэлцүүлгээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх хүртэл уг захиргааны хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн.<br><br>**ХОЁР:** Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газраас авах шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авахаар 2024 онд нийт 13 албан бичиг ирүүлсэн бөгөөд тус албан бичитг дурдсан нотлох баримт болон шаардлагатай баримт мэдээллийг цаг хугацаанд нь нотлох баримтын шаардлага хангуулан хүргүүлэн ажилласан. Үүнд:<br>1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд-6<br>2. Иргэний хэргийн анхан шатны шүүхэд- 5<br>3. Авлигалтай тэмцэх газар-1<br>4.Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт-1 албан бичгийг тус тус явуулсан. | |
| 4 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Нэгжийн дотоод эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэх ажилд оролцсон байна. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор ХЗДХЯ, Монголын цахим институт, Монгол улсын MNS ISO 31010:2016 стандарт, ҮТХороо зэрэг төрийн байгууллагын Байгулллагын эсдэлийг тодорхойлсон эрх зүйн баримт бичгийг судлаж тус нэгжийн дотоод эрсдэлийг ангилан, тогтоосон болно. Үүнд:<br>1. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл,<br>2. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл,<br>3. Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл,<br>Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл, | 01.01-12.10 |
| 5 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй | УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн | 01.01-12.10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулсан арга хэмжээ | | | байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх | хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх ажилд хамтран арга зүйн зөвлөгөө өгч ажилласан болно.<br>ГЕГ-т хамаарах<br>- УИХ-ын тогтоол - 3<br>- Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж - 1<br>- Засгийн газрын тогтоол - 5<br>- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 12<br>нийт 21 тогтоол шийдвэрийн биелэлт. | |
| 6 | Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | - | 2.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажиллана. | Тайлант хугацаанд 41 албан бичиг ирснээс ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодоос 9, яам болон төрийн бусад байгууллагаас 29, аж ахуйн нэгж, байгууллагаас 3 албан бичиг ирсэн. Үүнээс 35 хариутай бичгийн хариуг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд 65 албан бичиг явуулснаас ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодод , яам болон төрийн бусад байгууллагад 42 , хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад 3 албан бичиг явуулсан. Мөн гаалийн байгууллагад гаргасан 1 гомдлын хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.<br><br>ЗББН-үүдтэй хамтран ажилласан байдал:<br>Тайлан хугацаанд Гаалийн ерөнхий газрын ЗББН-үүдээс өөрт хуваарилагдан ирсэн 59, бусад зохион байгуулалтын нэгж рүү хариу болон бусад явуулсан 78 дотоод зурвас нийт 137 зурвасаар харилцан мэдээлэл солилцож эрх зүйн зөвлөмж чиглэл өгч ажилласан байна. | 01.01-12.10 |
| 7 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс | Гаалийн улсын байцаагч Б.Дүүриймаа нь 2024 онд нийт ажлын 18 хоног амрах эрхтэй бөгөөд ажлын 10 хоног амарсан байна. Ажлын 8 | 01.01-12.10 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>сайжруулж ажиллаж, үр дүнг тайлагнана.</td><td>хоногийн амралатаа аваагүй бөгөөд бусад цагт нь бүрэн ажилласан болно.</td><td></td></tr>
<tr><td>8</td><td>Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.</td><td>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</td><td>-</td><td>1.Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.</td><td>1.ГЕГ-ын дарга болон Дэд даргын албан тушаалын тодорхойлолтын төслийг хянаж холобгдох засвар, өөрчлөлтийг оруулан ЗУГ-т хүлээлгэн өгсөн.<br><br>2.“Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам” сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10.00-11.00 цагт харьяа гаалийн газа, хорооны захиргаа, хүний нөөц хариуцсан албан хаагчдад Захиргааны ерөнхий хуулийн хувийн хэрэг хөтлөх, сонсох ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтын талаарх арга зүйн сургалтыг Хуулийн хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Ч.Тамираа, гаалийн улсын байцаагч Э.Ганболд нартай зохион байгуулж, дэлгэрэнгүй мэдээлэл өгч, оролцогчдын тулгамдсан асуултад зөвлөгөө өгч, харилцан ярилцлага зохион байгуулав.</td><td>01.01-12.10</td></tr>
<tr><td>9</td><td>. Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр цахим хуудсаар дамжуулан түгээх.</td><td>Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байх;<br>-Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</td><td>-</td><td>1. Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр цахим хуудсаар дамжуулан түгээх ажлыг зохион байгуулсан байна.<br>2. Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг өөрийн болон бусад байгууллагын мэдээллийн эх сурвалжаар олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг</td><td>Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалтын хүрээнд 2024 онд шинээр боловсруулсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан дараах Захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төсөлд 30 хоногт иргэд, олон нийтээс санал авахаар Гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд байршуулав. Үүнд:
<table>
<tr><td rowspan="2">№</td><td colspan="2">2024 он</td></tr>
<tr><td>Захиргааны хэм хэмжээний актын нэр</td><td>Санал авах хугацаа</td></tr>
<tr><td>1</td><td>ГЕГ-ын даргын 2022 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл</td><td>2024.03.15-2024.04.15</td></tr>
<tr><td>2</td><td>ГЕГ-ын даргын 2008 оны “Журам батлах тухай” 680 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Бараа устгах горим хэрэгжүүлэх журам”-ын төсөл</td><td>2024.04.17-2024.05.17</td></tr>
<tr><td>3</td><td>ГЕГ-ын дарын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тушаалын төсөл</td><td>2024.04.04-2024.05.04</td></tr>
</table></td><td>01.01-12.10</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулах. | (see below) | |

| | | |
|---|---|---|
| 4 | "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам"-ын шинэчилсэн найруулгын төсөл | 2024.04.08-2024.05.08 |
| 5 | ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын төсөл | 2024.04.30-2024.05.30 |
| 6 | “Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын төсөл | 2024.06.10-2024.07.11 |
| 7 | ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг<br>журам”-ын шинэчилсэн найруулгын төсөл | 2024.06.12-2024.07.12 |
| 8 | ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар” -ын төсөл | 2024.06.24-2024.07.24 |
| 9 | ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-ын төсөл | 2024.06.24-2024.07.24 |

1 АТГ-ын ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/4936 дугаартай “Журам хянасан тухай” албан бичгийн дагуу ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл боловсруулж, Гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 30 өдрийн хооронд байрлуулан, 2024.05.06-ны өдрийн онлайн хурлын үер үүрэг өгч харьяа гаалийн газар хороодоос албан бичгээр, ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас дотоод зурвасаар санал авч нэгтгэн ажиллав.

Нийт 17 нэгжээс 46 санал ирсний 20 саналын утга, агуулга давхцсан бөгөөд 26 саналыг уг журмын төсөлд тусган батлуулсан байна.

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биел... ху... |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрэх түвшин | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | Төрийн албан хаагчийн богино хэмжээний мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн. | Богино болон дунд хугацааны сургалт, холбогдох сургалтад хамрагдах | Дунд хугацааны сургалтад хамрагдсан. | 01.01 11.10 | 10 |
| 2 | Англи хэлний дунд түвшиний мэдлэгээ дээшлүүлэх (танхим боло онлайн сургалтад хамрагдах) | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Англи хэлний анхан шатны танхимын сургалтад суралцаж төгссөн. | Англи хэлний түвшингээ дээшлүүлсэн байна. | Онлайн сургалтад хамрагдаж Англи хэлний түвшингээ дээшлүүлсэн. | 01.01-12.08 | 95 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛИЙН ХЭЛСТИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ............................ /Б.ДҮҮРИЙМАА/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ДҮҮРИЙМААГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хуулийн хэлтэс

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 4: "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | |
| 1. | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал | 60 56 | 10 | 70 | 58 |
| 2. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ | 60 58 | 10 | 70 | 60 |
| 3. | Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал | 60 | 10 | 70 | 60 |
| 4. | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах | 60 | 9 | 70 | 60 |
| 5. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 60 | 10 | 70 | 57 |
| 6. | Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | 60 | 10 | 70 | 60 |
| 7. | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | 70 |
| 8. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна. | 60 | 10 | 70 | 59 |
| 9. | Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах | 60 | 10 | 70 | 56 |
| 10 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа | 60 | 10 | 70 | 55 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | | | |
| **Дундаж оноо:** | | | **70.0** | 59,4 |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | 14 | 14 | 14 |
| 2. | Англи хэлний дунд түвшиний мэдлэгээ дээшлүүлэх (танхим болон онлайн) | 14 | 14 | 12 |
| **Дундаж оноо:** | | | **14** | 13 |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 7 | 6 |
| 3. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 7 | 6 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| **Дундаж оноо:** | | **7** | 6,6 |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| № | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо: 8** | | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| № | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар(арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 8 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7 |

171

| | | |
|---|---|---|
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | 87 |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **99** |

***Үнэлгээ өгсөн:***
***Нэгжийн дарга:***
Хуулийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Ч.Тамираа)

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***
***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .............................. (Б.Дүүриймаа)

.............................. *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***
***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

XII/20, 2024 *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч

.............................. (Ө.Тэгшээ)

2024. 12. 20 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***
***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

.................................. *(огноо)*